

Квадратын хүрээгээр

$N \times N$ хэмжээтэй квадрат массивыг жишээн дээрх загвараар дүүргэ.

Input

Квадрат массивын хэмжээ натурал тоо N өгөгдөнө. $N < 10$.

Output

Квадрат массивын элементүүдийг мөр мөрөөр нь хэвлэнэ.

Гэхдээ элемент бүрийг 3 хоосон зайд хойш нь шахаж хэвлэнэ. Жишээг сайн ажиглана уу.

Жишээн дээрх 1-ийн тоо гэхэд урдаа, хойноо тус бүр 2 хоосон зайтай байна.

Мөн 16-ын тоо урдаа, хойноо тус бүр 1 хоосон зайтай байна.

Example

Input:

5

Output:

```
1 2 3 4 5
16 17 18 19 6
15 24 25 20 7
14 23 22 21 8
13 12 11 10 9
```